



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/791

Ховд

Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/329 дүгээр тушаалаар баталсан нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийн 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Аймгийн нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд:

-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Захиргаа, хяналтын хэлтсийн дарга

-Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

-Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газрын хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн

-Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд, эмэгтэйчүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн

-Боловсрол, соёл урлагийн газрын хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Үйл ажиллагааныхаа тайланг хагас, бүтэн жилээр гаргаж Монголын нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хороонд хүргүүлж ажиллахыг аймгийн нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороо /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ